



2020

Annual Report



Our Purpose

To serve humanity so all may live as God intended.

MESSAGE from the COUNTRY DIRECTOR



The year 2020 was catastrophic when the pandemic hit the world by surprise as it halted the world economies into a standstill and millions suffered while the pall of death seems unabated following the Covid-19 outbreak in Wuhan, China in the early part of the year.

ADRA Mongolia's team remain focused on its purpose as a faith-based organization in serving humanity so that all may live as God intended while recognizing the dignity that is inherent in each person and serves the disenfranchised without regard to their ethnic, gender, political or religious affiliation.

Amidst the intermittent lockdowns to curb the further spread of the deadly virus which wreaked havoc throughout the world including Mongolia, our team was undeterred to make sure that the implemented projects in different parts of the country are looked after and on-track without sacrificing the safety and security of everyone.

Furthermore, through working with our donor partners, we had served a total of 11,303 vulnerable individuals and beneficiary partners in Selenge and Bayan-Ulgii aimags (provinces) where we continue to promote a sustainable initiative on organic agriculture and vegetable farming and as a source of livelihood. As well, our team initiated a Covid-19 emergency response in Ulaanbaatar particularly in Bayangol and Chingeltei districts through cash transfers to vulnerable households at the height of the pandemic.

With the challenges ahead, we are always encouraged by the dedication and commitment of the team and remain strategic in doing our work and that every beneficiary partner is attended and supported in the best possible way while navigating the “new normal”. We remain committed to do the work that God had entrusted us to do with a resolve to be part of the solution especially those who are in most need and on the margins of society.

I invite you to have the opportunity of witnessing God's leadership in the work that our team accomplished on this 2020 Annual Report.


God's richest blessings,

A handwritten signature in black ink, appearing to read 'Winzell M. Maranan'. The signature is fluid and cursive, written over a light blue curved graphic element.

WINDELL M. MARANAN
Country Director

Contents

Message from the C.D	3
About ADRA	5
Where We Serve	6
Economic Development/Food Security	8
Partnership for Organic Agriculture Project	
Badam's Story	
Economic Development/Food Security	10
Sustainable Agriculture, Food/Economics Resilience-2 Project	
Khumar's Story	
Emergency/Disaster Management/	12
Covid-19 Aid Mongolia Project	
Enkhtuul's Story	
Finances	14
Our Donors and Partners	15
Justice, Compassion, Love	16



About Adra

The Adventist Development and Relief Agency is an independent humanitarian agency established in 1956 by the Seventh-day Adventist Church.

ADRA seeks to identify and address social injustice and deprivation in developing countries. The agency's work seeks to improve the quality of life of those in need. ADRA is operating in 134 country offices, one of which is in Mongolia.

ADRA opened its door to Mongolia in 1994 and partners with individuals, communities, organizations, and governments to improve the quality of life for Mongolians through five programs activities:

- Food Security
- Economic Development
- Health Education
- Disaster Management
- Youth and Education

Motto

Justice. Compassion. Love

Mission

ADRA works with people in need and distress to create just and positive change through empowering partnerships and responsible action.


Vision

ADRA Mongolia belongs to a professional, learning and efficient network that embodies integrity and transparency. ADRA reaches across boundaries, empowering and speaking out for the at-risk and forgotten to achieve measurable, documented and durable changes in lives.

Identity Statement

The Adventist Development and relief Agency is a global humanitarian organization of the Seventh Day Adventist Church that demonstrates God's love and compassion.

Where we serve



Donors

ADRA Canada and Canadian Food Grains Bank

Beneficiaries

845 household of targeted 3 soums/districts



Location

Ulgii, Bugat and Sagsai districts of Bayan-Ulgii province, Mongolia.

Budget

375,637.00 USD

Duration

2020 – 2023

Partnership For Organic Agriculture Project (POAg)

Donors

BMZ, ADRA Germany

Beneficiaries

31 cooperatives
(928 members)

Location


11 soums in Selenge Aimag

Budget

1,258,860.00 USD

Duration

2018-2022



Covid-19 Aid Mongolia Project (CAMO)

Donors

ADRA International, ADRA Asia,
and Mongolia Mission of
Seventh-day Adventist

Beneficiaries

315 Households
(1674 individuals)

Location

Ulaanbaatar city

Budget

35,000.00 USD

Duration

April 14 - July 1, 2020





Economic Development/Food Security

PARTNERSHIP FOR ORGANIC AGRICULTURE PROJECT

Donors	Beneficiaries	Budget	Duration
BMZ, ADRA Germany	31 cooperatives (928 members)	1,258,860.00 USD	2018-2022

Selenge Province

The goal of the project is to develop organic agricultural production, establish a Participatory guarantee system (PGS), and improve the livelihoods of smallholder farmers in Selenge province. Furthermore, we are working to increase consumer awareness of organic agriculture, improve the capacity and governance of project cooperatives, produce value-added end products through the introduction of organic products, and contribute to providing healthy and safe food.

The Partnership for Organic Agriculture project has been successfully implementing its goals and objectives since September 1, 2018, and is currently working with 928 members of 30 primary cooperatives in 11 soums of Selenge province. Our primary cooperatives are engaged in organic vegetable farming and bee farming.

Selenge province is known as a breadbasket area of Mongolia. Therefore, most members of the cooperative grow vegetables, and some of them are engaged in beekeeping and livestock. In 2020, 1137 cooperative members were engaged in

organic agriculture, cooperative governance and management, business and vocational training. Also, more than 250 farmers who took the oath of allegiance to organic farming planted 29 types of vegetables on 206 hectares in accordance with the organic standards. They harvested a total of 1,975 tons of certified organic vegetables and seven tons of organic honey, and sold 1.1 billion MNT worth of products locally and in Ulaanbaatar.

Seasonality of agricultural income is one of the biggest challenges being faced by the people in the agricultural sector. The project provided the cooperatives with small-scale equipment for off-season business activities based on their needs and business plan to diversify their income and ensure sustainability.

As a result, cooperatives established small workshops such as baking, sewing, and producing dairy products, making organic fertilizers and felt products in the community. Besides, they opened the "Selenge Organic" store in August 2020 in Ulaanbaatar and the brand was created because of their collaborative mind and hard work.





BADAM'S STORY

“I am grateful to donors and ADRA that helped us to be organic farmers and contribute to producing healthy products and creating a friendly environment to nature”. -Badam

Ms. Badam worked as a secretary for the local court during the socialist time in Zuunkharaa soum, Selenge province. Unfortunately, she lost her job due to staff downsizing in 2001. After that, Badam and her husband, Yura, started to grow vegetables in their small plot. For almost a decade they grew vegetables, but their income was not enough.

Therefore, she decided to establish a cooperative named “Zuun Kharaa Baylag” with 14 farmers of the soum in 2011. Also, Badam was elected director of the cooperative, and her cooperative was selected as one of the beneficiaries of Partnership for Organic Agriculture project in 2018. Since that time, they have been learning how to grow vegetable under organic standards.

In October 2018, they started participating in the “Partnership for Organic Agriculture” project to produce and deliver

certified organic products to consumers, followed by value-added dried (parsley, anise, beet) and pickled products (beet salad, chequered salad, cabbage salad).

In addition, by increasing the variety of vegetables in spring planing, they can meet their household needs with more than 20 varieties and promote organic production in the soum. Her cooperative sold in 2019, “Selenge Organic” store and exhibition 17 million MNT, and in 2020, 19 million MNT.

S.Badam has become a champion of the soum in 2020 by encouraging organic farming, increasing the yield from small areas, and her annual income.





Economic Development/Food Security

SUSTAINABLE AGRICULTURE, FOOD & ECONOMICS RESILIENCE-2 PROJECT (SAFER-2)

Donors	Beneficiaries	Budget	Duration
ADRA Canada and Canadian Food Grains Bank	845 household of targeted 3 soums/districts	375,637 USD	2020-2023

Bayan-Ulgii Province

The Sustainable Agriculture, Food and Economics Resilience-2 project is based on the achievements and experience of the home gardening development project in 2011-2014 years and the cooperative agriculture development project in 2015-2019. The ultimate outcome of the project is to increase the food and nutrition, security and improve the livelihoods of 845 vulnerable households who are living in mountainous areas with harsh climates in Bayn-Ulgii province.

The first year of the project started on April 1, 2020 and 15 people have been selected as Master Gardener Trainers (MGTs) based on their experiences as well as speaking and communication skills in their previous projects. Each MGT is in charge of 10 households and regularly visits and teaches the beneficiary members.

Trainers have specific responsibilities and key in working with the project team. Together with the project agronomist and training specialist, the 15 MGTs conducted theoretical

and practical trainings on home gardening with their respective groups under the guidance and supervision of the SAFER project team.

150 households were selected as master gardeners from the three target soums and were involved in the first year of the project and the agricultural trainings. These trainings have eight sessions with 34 topics in the developed agriculture training curriculum which included basic knowledge in gardening and new technologies with new methods such as permaculture practices and Mittleider methods with raised boxes and cold frames.

Furthermore, all target households were provided with 12 types of vegetable seeds and three types of hand tools, and they are cultivating successfully. Kitchen clubs were also established in three target soums to provide members with food training, which began on August 1, 2020, and was led by a professional chef and trainer. Preparations are underway to publish agricultural and cooking manuals with detailed explanations to be distributed to all households.



KHUMAR'S STORY

“I am very thankful to ADRA Mongolia's SAFER-2 Project and wishing to share my newfound wealth of growing vegetables to others through home gardening” - Khumar



T. Khumar lives with his wife and son's family in one house. There are seven people but no one in his household is employed, and the household total income is 600,000 MNT, including his wife's state welfare allowance, child support for his three grandchildren from the government, and his son's seasonal casual worker salary at the local market.

However, this amount of money does not meet all needs of his family. Therefore, Khumar became a member of the agriculture activity cooperative in 2015 and began to learn how to grow vegetables more diligently than others. Due to the fenced houses are on the riverbank, the houses tend to be low-quality, built of ash blocks with small clay greenhouses.

Vegetable gardens are often flooded during groundwater levels and require regular maintenance. Khumar is happy to say that using the method to plant in the boxes and narrow beds taught by Aleksey, an international agricultural consultant, is helped him to avoid flooding.

This year, he planted cucumbers in early April during the cold days by heating the greenhouse. Thanks to this hard work, Khumar became a farmer who had his first crops early, by June 25, and sold them at a good price per kg. It was a great action that made the project team happy.

By the end of September, he had harvested around 700kg of crops from the greenhouse, earned about 2,800,000 MNT (1400CAD\$) selling at the local market, and could use the earnings for various household needs. He really enjoys Agriculture training and never misses them.

He said "I really interested in growing cabbage but it was difficult due to weather conditions and soil quality. But thanks to agricultural training, I was able to take good care and harvest a good crop of cabbage.





Emergency/Disaster Management

COVID-19 AID MONGOLIA PROJECT

Donors

ADRA International, ADRA Asia, and Mongolia Mission of Seventh-day Adventist

Beneficiaries

315 Households (1674 individuals)

Budget

35,000 USD

Duration

April 14 - July 1, 2020



Ulaanbaatar City

Following the COVID-19-outbreak in Wuhan, China, the government of Mongolia closed all air and land border crossings with China, and as of mid-February have suspended all international flights and passenger trains.

Furthermore, all public events (conferences, sports games, festivals, religious meetings, etc.) have been canceled and all educational institutes remained closed across the country until June 30. Citizens have been prohibited from traveling internationally, and anyone returning to the country is subject to a 21-day quarantine.

On March 10, Mongolia reported its first coronavirus case. As of June 14, there were 197 confirmed cases of COVID-19, all of which are imported cases.

However, while an outbreak of COVID-19 has been controlled so far through these measures, the country is still being affected by

the pandemic in an economic sense. Certain workplaces have reduced their hours, resulting in individuals losing a partial amount of their income, while others have completely lost their jobs, resulting in the inability to provide for their households.

ADRA Mongolia recognized that low-income families with many children, or those caring for the elderly and disabled, as well as single parents, are the most economically implicated. This emergency response worked under the Cash Assistance sector. It was implemented in Ulaanbaatar from April 14 to July 1 with the collaboration of the Seventh-day Adventist Mongolia Mission (MM) and Social Welfare and Protection Departments of the Bayangol and Chingeltei districts.

A total of 315 households (1674 individual family members as beneficiaries) have received direct aid through cash transfers. Each beneficiary household received \$100 USD (275,000 MNT in local currency) into their bank account and a cash voucher certificate.



ENKHTUUL'S STORY

“I feel really lucky that ADRA has chosen to help my family. I know many families like mine who are going through a hard time, so I'm appreciative for the help we're receiving.” – Enkhtuul



Enkhtuul lives in Ulaanbaatar city, the capital of Mongolia. At 19 years old, Enkhtuul is in her second year of university, where she is studying the Korean language and culture. In her first year, she worked while studying to contribute to her family's income and help pay for her tuition, but this proved to be too much to manage. This year, she decided not to work while studying, but after her first semester, it became apparent that she would need to work again to help her family.

She began looking for employment, but there were no jobs available to her. Due to the government restrictions and its attempts to promote social distancing, many workplaces have had to reduce working hours or let people go entirely. Enkhtuul believes this is why she isn't able to find work. This also affects her mother, who earned a living working odd household jobs for people. Because of social distancing, families have stopped offering her employment.


Currently, Enkhtuul's family's only source of steady income comes from her grandmother's pension and the government's child-support monetary given to her mother. Enkhtuul has had to drop out of school this semester because this amount is not enough to cover her tuition costs. She is thankful because the \$100 USD she received from ADRA Mongolia and its partners is equivalent to her grandma's monthly pension. This means that for at least one month, she won't have to worry about her family.

Despite her challenges, Enkhtuul dreams of a bright future. After the government restrictions are lifted, she will work hard to finish university and go to Korea, where she wants to attend grad school and work to support her family. Though she has many dreams for herself, her biggest dream is to be able to financially care for her loved ones.



Finances

#	Department/Project	Donors	Total budget (in USD)	Expenses 2020 (Mongolian tugrug)
1	Sustainable Agriculture, Food & Economics Resilience Project (SAFER 2)	ADRA Canada and Canadian Food Grains Bank	\$375,637.00	157,473,016.00 MNT
2	Partnership for Organic Agriculture Project (POAg)	ADRA Germany, BMZ	\$1,258,860.00	680,736,108.00 MNT
3	Covid-19 Aid Mongolia Project (CaMo)	ADRA International, ADRA Asia, and Mongolia Mission	\$35,000.00	98,179,174.00 MNT
4	ADRA Mongolia International Organization Administration		\$116,465.00	287,870,722.00 MNT
Total				1,224,259,021.00 MNT



Our Donors and Partners



германы
хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Ministry of Food,
Agriculture and Light Industry (MOFALI)



Canadian
Foodgrains
Bank

A Christian Response
to Hunger



Selenge Governor's Office



Bayan-Ulgii Governor's Office



SEVENTH-DAY
ADVENTIST CHURCH
MONGOLIA MISSION



ADRA
Canada



Institute for Plant and Agricultural
Sciences (IPAS)



ADRA



Selenge Tavan Khairkhan Cooperative Union



Consumers' Rights Association



National Association of Mongolian
Agricultural Cooperatives (NAMAC)



Just
Compo
Lo





*Justice.
Passion
Love*



Донор болон Хамтрагч Байгуулмалууд



германы
хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Хүнс хөдөө аж ахуйн яам



Canadian
Foodgrains
Bank

A Christian Response
to Hunger



Сэлэнгэ аймгийн ЗДТГ



Баян-Өлгий аймгийн ЗДТГ



SEVENTH-DAY
ADVENTIST CHURCH
MONGOLIA MISSION



Дарханы Ургамал газар тариалан
эрдэм шинжилгээний институт



ADRA
Canada



ADRA



Сэлэнгэ Таван Хайрхан Дундын Хоршоо




Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах
нийгэмлэг



Монголын хөдөө аж ахуйн
хоршоологчдын нэгдсэн холбоо

Санхүүжилт

#	Хөтөлбөр/Төсөл	Санхүүжүүлэгч байгууллага	Төслийн нийт төсөв (ам.доллар)	2020 оны зардал (төгрөгөөр)
1	Өрхийн газар тариаланг дэмжих төсөл	АДРА Канад, Канадын Хүнсний Үр тарианы Банк	\$375,637.00	157,473,016.00 ₮
2	Органик хөдөө аж ахуйн түншлэл төсөл	АДРА Герман, Германы Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн яам	\$1,258,860.00	680,736,108.00 ₮
3	Ковид-19 цар тахлын жаралтай тусламж төсөл	АДРА ОУБ, АДРА Ази, Монголын Адвентист Чуулган	\$35,000.00	98,179,174.00 ₮
4	АДРА Монгол ОУБ-ын захиргаа/		\$116,465.00	287,870,722.00 ₮
НИЙТ				1,224,259,021.00 ₮



ЭНХТУУЛЫН ТҮҮХ

“АДРА байгууллага манай гэр бүлд туслахаар сонгосонд би үнэхээр баяртай байна. Манайх шиг хүнд хэцүү цаг үеийг туулж буй олон гэр бүлийг би мэднэ тиймээс бидэнд үзүүлж буй тусламжид маш талархаж байна.” - Энхтуул




Энхтуул нь Улаанбаатар хотод амьдардаг ба 19 настай их сургуулийн хоёрдугаар курст Солонгос хэл, соёлын чиглэлээр суралцаж буй оюутан юм. Тэрээр их сургуулийнхаа эхний жил гэр бүлийнхээ орлогод хувь нэмрээ оруулах, сургалтын төлбөрөө төлөхөд туслах зорилгоор сурч байхдаа ажиллаж байсан боловч бүгдийг нь амжуулахад хэтэрхий их байжээ. Энэ жил тэрээр сурч байхдаа ажиллахгүй байхаар шийдсэн боловч эхний семестрийн дараа гэр бүлдээ туслахын тулд дахин ажиллах шаардлагатай болсон байна.

Тэрээр цагийн ажил хайж эхэлсэн боловч түүнд ажил олоход хүндрэлтэй байгаа юм. Учир нь гэвэл засгийн газрын хязгаарлалт, хөл хорио тавьж албан байгууллагууд ажлын цагийг багасган, зарим тохиолдолд ажилчдаа ажлаас нь чөлөөлөх шаардлагатай болсон байна. Түүнчлэн хөл хорионоос болж гэрийн үйлчлэгч хийдэг байсан ээж нь ажлаа үргэлжлүүлэх боломжгүй болсон байна.

Одоогийн байдлаар Энхтуулын гэр бүлийн тогтвортой орлогын цорын ганц эх үүсвэр нь эмээгийнх нь тэтгэвэр болон засгийн газраас олгодог хүүхдийн тэтгэмж юм. Энэ нь түүний сургалтын төлбөрийг төлөхөд хангалттай хүрэлцэхгүй учраас Энхтуул энэ семестэр сургуулиа орхиход хүрчээ. Тэрээр АДРА Монгол болон түүний түншүүдээс авсан 100 доллар нь эмээгийнхээ сарын тэтгэвэртэй тэнцэж байгаа тул дор хаяж нэг сарын хугацаанд гэр бүлийнхээ санхүүд санаа зовохгүй гэсэн үг юм.

Эдгээр хүнд сорилтуудыг үл харгалзан Энхтуул гэрэлт ирээдүйг мөрөөддөг ба хамгийн том хүсэл нь хайртай хүмүүсээ санхүүгийн хувьд хангах чадвартай болох юм. Тэрээр их сургуулиа төгсөөд Солонгос улсруу явж сурч боловсрохын зэрэгцээ ажиллах хүсэлтэй ба тэр зорилгынхоо төлөө тууштай хичээж байгаа юм.





КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ ТӨСӨЛ

Санхүүжүүлэгч	Төслийн үр шим хүртэгсэд	Төсөв	Хэрэгжих хугацаа
АДРА ОУБ, АДРА Ази, Долоо дахь өдрийн Адвентист сүм	315 өрх (1674 хүн)	35'000.00 ам.доллар	2020 оны 4-р сарын 14-ээс 7-р сарын 1 хүртэл

Улаанбаатар хот

БНХАУ-ын Ухань хотод “Ковид-19”-ийн цар тахал тархсаны дараа Монгол Улсын засгийн газар Хятад улстай агаарын болон хуурай замын хил боомтоо хааж, хоёрдугаар сарын дунд үеэс эхлэн олон улсын бүх нислэгүүд болон зорчигч тээврийн галт тэрэгнүүдийг зогсоосон. Түүнчлэн бүх нийтийн арга хэмжээнүүд (хурал цуглаан, спортын наадам, баяр ёслол, шашны уулзалт гэх мэт) цуцлагдаж, мөн боловсролын байгууллагууд 6-р сарын 30 хүртэл улс даяар түр хаах шийдвэр гаргасан. Үүнээс гадна иргэдийг олон улсад аялахыг хориглосон бөгөөд эх орондоо буцаж ирсэн хүн бүр 21 хоногийн хорио цээрийн дэглэм тогтоосон.

Гуравдугаар сарын 10-нд Монгол Улс коронавирусын анхны тохиолдолдоо мэдээлсэн ба 6-р сарын 14-ний байдлаар Ковид-19-ийн батлагдсан тохиолдол 197 хүрсэн бөгөөд бүгд гаднаас орж ирсэн тохиолдлууд байв. Хэдий засгийн газар

халдварын тоог хяналтдаа авч байсан ч цар тахлын эдийн засгийн нөлөөнд одоог хүртэл автсан хэвээр байгаа юм. Тодорхой ажлын байрууд ажлын цагаа багасгаж үүнээс шалтгаалан хувь хүмүүс орлогынхоо зарим хэсгийг алдаж, зарим нь бүр ажилгүй болж улмаар гэр бүлээ тэжээх боломжгүй болсон юм.

АДРА Монгол нь орлогын төвшин бага олон гишүүнтэй гэр бүл, болон өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, түүнчлэн олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эх нар нь эдийн засгийн хувьд хамгийн их хямралтай гэж үзсэн. Үүний дагуу онцгой байдлын хариу арга хэмжээ авч “Бэлэн мөнгөний тусламж”-ийн хүрээнд ажилласан.

Долоо дахь өдрийн Адвентист сүм, болон Баянгол, Чингэлтэй дүүргийн Нийгмийн халамж, хамгааллын хэлтсүүдтэй хамтран Улаанбаатар хотод 4-р сарын 14-өөс 7-р сарын 1-ний хооронд энэхүү төсөл маань хэрэгжсэн ба нийт 315 өрхөд (гэр бүлийн 1674 гишүүд) бэлэн мөнгөөр шууд тусламж үзүүлсэн. Үр шим хүртэгч өрх бүр 100 доллар буюу (275,000 төгрөг) дансандаа хүлээн авч, гэрчилгээг мөн гардаж авсан.



Т.ХУМАРЫН АМЖИЛТЫН ТҮҮХ

"АДРА Монгол-ийн SAFER -2 төсөлд би маш их талархаж байгаа бөгөөд гэрийнхээ цэцэрлэгтээ тарисан шинэ хүнсний ногоогоо бусадтай хуваалцахыг хүсэж байна." - Хумар



Т.Хумар нь эхнэр, хүүгийнхээ гэр бүлтэй хамт долуулаа нэг гэрт амьдардаг. Тэдний гэрт тухайн үед тогтсон ажилтай хүн байгаагүй ба өрхийн орлого нь эхнэрийнх нь төрөөс олгодог халамжийн мөнгө, өөрийн тэтгэвэр, 3 ач нарт нь олгодог хүүхдийн тэтгэмж болон хүүгийнх нь улирлын чанартай хар зах дээр хийдэг ажлын цалин нь нийлээд 600,000 төгрөг байсан юм. Гэвч энэ нь ам бүл олуулаа тэдний бүх хэрэгцээг хангадаггүй байв. Тиймээс Хумар 2015 оноос хоршооны шинэ гишүүнээр орж хүнсний ногоо тариалах ажилд хэн бүхнээс илүү шамдан суралцаж эхэлсэн.

Хашаа байшин нь голын эрэг хавьцаа байдаг учир үнсэн блокоор барьсан чанар муутай байшин, жижиг шавар хүлэмж болон ногооны талбай нь хөрсний ус дээшлэх үед усанд автаж байнгын засвар, шинэчлэлт шаарддаг байжээ. Олон улсын газар тариалангийн зөвлөх Алексейн заасан хайрцаглан тарих аргыг хэрэглэснээр усанд автах бэрхшээлээс салсан гэдгээ Хумар баяртайгаар хэлсэн юм.

Энэ жил хүлэмждээ өргөст хэмх эрт тарьж 4 сараас гал түлэн цочир хүйтрэхээс хамгаалж чадсан тэрээр ногоочдоос хамгийн түрүүнд 6 сарын 25 гэхэд анхны ургацаа хураан борлуулалт хийн 1 кг-ыг 5000 төгрөгөөр борлуулж ашигтай ажиллаж чадсан нь төслийн багийнхан биднийг хүртэл баярлуулсан явдал байлаа.

Есдүгээр сарын эцэс гэхэд нийтдээ 700 кг орчим өргөст хэмх хурааж өрхийнхөө хэрэгцээг хангасны дээр борлуулалт хийн хүлэмжийн ургацаас 2 сая 800 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна. Тэрээр хөдөө аж ахуйн чиглэлийн дагуу явагддаг сургалтад маш идэвхтэй бөгөөд хэзээ ч хоцорч үзээгүй юм. Цаг уурын нөхцөл байдал, хөрсний чанараас шалтгаалан байцаа тарих нь хэцүү бөгөөд хүмүүс амархан шантардаг гэж тэрээр хэлсэн юм. Гэхдээ Хумар арчилгаа сайн хийснээр байцаа элбэг ургац хурааж авах боломжтойг харуулсан.





Хүнсний аюулгүй байдал

ӨРХИЙН ГАЗАР ТАРИАЛАНГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

Санхүүжүүлэгч

АДРА Канад болон
Канадын үр тарианы
банк

Төслийн үр шим хүртэгсэд

Зорилтот сумдын 845 өрх
болон өрхийн гишүүд

Төсөв

375,637.00
ам.доллар

Хэрэгжих хугацаа

2020-2023



Баян-Өлгий аймаг

Өрхийн газар тариаланг дэмжих төсөл нь 2011-2014 оны хооронд хэрэгжүүлсэн “Тогтвортой газар тариаланг хөгжүүлэх” анхны төсөл болон 2015-2019 оны хооронд хэрэгжүүлсэн “Хоршооны газар тариаланг хөгжүүлэх” төслийн ололт амжилт, туршлага дээр суурилсан төсөл юм. Төслийн гол зорилго нь Баян-өлгий аймгийн цаг агаарын эрс тэс уур амьсгалтай уулархаг бүс нутагт аж төрж буй нийгмийн эмзэг бүлгийн 845 өрхийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулж, хоол тэжээлийн чанарыг нэмэгдүүлэх болон амьжиргааны төвшинг дээшлүүлэхэд оршино.

Энэхүү төсөл нь 2020 оны 4-р сарын 1-нээс үйл ажиллагаагаа эхэлсэн ба өмнөх төслүүдэд хамрагдаж байсан байдал, газар тариалан эрхэлсэн туршлага болон харилцааны чадвар зэргийг харгалзан 15 хүнийг сонгон авч сургалтад түлхүү хамруулан мэдлэг чадварыг нь дээшлүүлэн газар тариалангийн сургагч багш болгон бэлтгэсэн. Сургагч багш нар нь өөрийн хүлээсэн тодорхой үүрэг даалгавартай ба төслийн баг хамт олонтой хамтран ажиллах гол хүмүүс юм. Төслийн агрономи болон сургалт хариуцсан мэргэжилтэнтэй хамтарч

уг 15 сургагч багш тодорхой нэр бүхий сургалтад хамрагдсаны дараа өөрийн хариуцсан өрхүүддээ уг сэдвийн дагуу онол болон дадлага сургалтыг төслийн багийнхны зөвлөгөө тусламж болон хяналт дор ажиллаж байна.

Өрхийн газар тариалан эрхлэх сургалтад зорилтот 3 сумаас төслийн эхний жилд хамрагдах 150 өрхийг сонгон авч батлагдсан хөтөлбөрийн дагуу 8 удаагийн газар тариалангийн Пермакултур болон Митлейдерийн аргыг эзэмшүүлэх онол болон дадлага сургалтуудыг амжилттай зохион байгууллаа. Зорилтот бүх өрхөд 12 төрлийн ногооны үр, 3 төрлийн гар багажаар хангаж, тариалалт амжилттай болсон билээ.

Түүнчлэн 2020 оны 8 -р сарын 1-ээс эхлэн гишүүдийг хоолны сургалтад хамруулах зорилгоор зорилтот 3 суманд гал тогооны клуб байгуулсан бөгөөд сургалтыг мэргэжлийн тогооч, сургагч багш нар удирдан явуулсан байна. Сургалтын хөтөлбөрт хамрагдсан сэдвээр дэлгэрэнгүй тайлбартай газар тариалангийн болон хоол хийх гарын авлагуудыг бэлтгэн хэвлүүлж төсөлд хамрагдсан өрх бүрд хүртээл болгосон байна.





С.БАДАМЫН АМЖИЛТЫН ТҮҮХ

"Органик үйлдвэрлэгч болж эрүүл байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд дэмжиж ажиллаж буй АДРА болон санхүүжүүлэгч байгууллагад маш их талархаж байна." -Бадам

Бадам нь социализмын үед Сэлэнгэ аймгийн Зүүнхараа суманд орон нутгийн шүүхийн нарийн бичгийн даргаар ажиллаж байжээ. Харамсалтай нь тэрээр 2001 онд ажилтнуудаа цомхтгосноос болж ажилгүй болсон бөгөөд үүний дараагаар Бадам болон түүний нөхөр Юра нар жижиг талбайдаа ногоо тарьж эхэлжээ. Бараг 10 жилийн турш тэд ногоо тарьж байсан ч орлого нь тийм ч хангалттай биш байв.

Тиймээс тэрээр 2011 онд тус сумын 14 ногоочинтой хамтран “Зүүн хараа баялаг” хөдөө аж ахуйн хоршоог байгуулсан. Түүнчлэн тэрээр хоршооны даргаар сонгогдон ажиллаж байгаа бөгөөд тус хоршоо нь 2018 оноос хойш "Органик хөдөө аж ахуйн түншлэл" төсөлтэй хамтран ажилласанаар органикийн стандартын дагуу органик хүнсний ногоо тарьж сурсан.

2018 оны 10 сараас эхлэн тэд АДРА олон улсын байгууллагын “Органик хөдөө аж ахуйн түншлэл” төсөлд хамрагдан баталгаажсан органик бүтээгдэхүүнийг

үйлдвэрлэн хэрэглэгчдэд хүргэж, улмаар нэмүү өртөг шингэсэн хатаасан (яншуй, гоньд, хүрэн манжин) болон даршилсан бүтээгдэхүүн (хүрэн манжингийн салат, алаг салат, байцайн салат) үйлдвэрлэж эхэлсэн юм. Түүнчлэн хаврын тариалалтад нарийн ногооныхоо төрлийг нэмэгдүүлж, 20 гаруй төрлийн хүнсний ногоогоор өрхийн хэрэгцээгээ ханган мөн сум орон нутагтаа органик үйлдвэрлэлийг сурталчлан таниулах замаар бүтээгдэхүүнээ борлуулдаг.

2019 онд “Сэлэнгэ органик” дэлгүүр болон үзэсгэлэн худалдаагаар 17 сая төгрөг, 2020 онд 19 сая төгрөгийн борлуулалт тус тус хийсэн байна. Бадам нь органик тариалан эрхлэх, түүнийг дэмжихийг өөрийн зорилго болгож, бага талбайгаас авах ургацын хэмжээгээ нэмэгдүүлэн, жил бүрийн орлогоо ахиулан 2020 оны сумын аварга ногоочин болсон юм.





Хүнсний аюулгүй байдал

ОРГАНИК ХӨДӨӨ АЖ АХУЙН ТҮНШЛЭЛ ТӨСӨЛ

Санхүүжүүлэгч

ХБНГУ-ын Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн яам, АДРА Герман

Төслийн үр шим хүртэгсэд

Орон нутгийн 31 хоршоо, тэдгээрийн 928 гишүүн

Төсөв

1,258,860.00 ам.доллар

Хэрэгжих хугацаа

2018-2022



Сэлэнгэ аймаг

Органик хөдөө аж ахуйн түншлэл төслийн зорилго нь Сэлэнгэ аймагт органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хамтын баталгаажуулалтын тогтолцоог бий болгох, жижиг фермерүүдийн амьжиргааг дээшлүүлэхэд оршино. Түүнчлэн органик хөдөө аж ахуйн талаар хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх, органик бүтээгдэхүүнийг олон нийтэд таниулах замаар нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн иргэдийг эрүүл аюулгүй хүнсээр хангах үйлсэд хувь нэмэр оруулан ажиллаж байна.

“Органик хөдөө аж ахуйн түншлэл” төсөл нь 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн зорилго, зорилтоо амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд одоогоор Сэлэнгэ аймгийн 11 сумын 30 анхан шатны хоршооны 928 гишүүнтэй хамтран ажиллаж байна. Анхан шатны 30 хоршоо нь органик хүнсний ногооны аж ахуй болон зөгийн аж ахуй үйлдвэрлэл эрхэлдэг. Сэлэнгэ аймаг бол Монголын үржил шим сайтай газар тариалангийн гол бүс нутаг юм.

2020 онд 1137 хоршооны гишүүд, төрийн байгууллагын ажилтнууд, хамтран ажиллагч талууд органик газар тариалан, бизнес

менежмент, хоршооны засаглал болон мэргэжлийн сургалтуудад хамрагдсан байна. Түүнчлэн органик газар тариалан эрхлэх шийдвэр гарган тангараг өргөсөн 250 гаруй ногоочид 206 га-д 29 төрлийн ногоог органик стандартын дагуу тариалж, 1,975 тонн баталгаажсан органик ногоо, 7 тонн органик зөгийн бал хураан авч, орон нутагтаа болон Улаанбаатар хотод 1,1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг зарж борлуулсан байна.

Хөдөө аж ахуйн салбар нь улирлын шинж чанартай учир тариаланчдын орлого тогтворгүй байдаг ба энэ нь тэдний хувьд томоохон бэрхшээлүүдийн нэг юм. Төсөл нь хоршоодын хэрэгцээ, бизнес төлөвлөгөөнд үндэслэн тэдний орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх, нэмэгдүүлэх зорилгоор газар тариалангийн бус улиралд төрөл бүрийн бизнес эрхлэхэд шаардлагатай жижиг оврын тоног төхөөрөмжийг олгосон. Үүний үр дүнд тэд хоршоондоо талх нарийн боов, оёдол, мужаан, органик бордоо, эсгий бүтээгдэхүүн, мах, сүүн бүтээгдэхүүний жижиг цехүүдийг байгуулж, төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, борлуулдаг болсон. Үүнээс гадна тэд "Сэлэнгэ Органик" бүтээгдэхүүний дэлгүүрээ 2020 оны наймдугаар сард Улаанбаатар хотод төслийн дэмжлэгтэйгээр нээсэн бөгөөд энэ нь тэдний хамтын ажиллагаа, шаргуу хөдөлмөрийн үр дүнд бий болсон билээ.



Органик хөдөө аж ахуйн түншлэл төсөл

Санхүүжүүлэгч

ХБНГУ-ын Эдийн засаг, хамтын
ажиллагаа, хөгжлийн яам,
АДРА Герман

Төслийн үр шим хүртэгчсэд

Орон нутгийн 31 хоршоо,
тэдгээрийн 928 гишүүн



Зорилтот газар:

Сэлэнгэ аймаг, 13 сум

Төсөв

1,258,860.00 ам.доллар

Хэрэгжих хугацаа

2018-2022



Ковид-19 Цар тахлын яаралтай тусламж төсөл

Санхүүжүүлэгч

АДРА ОУБ, АДРА Ази, Долоо
дахь өдрийн Адвентист сүм

Төслийн үр шим хүртэгчсэд

315 өрх (1674 хүн)



Зорилтот газар

Улаанбаатар хот

Төсөв

35,000.00 ам.доллар

Хэрэгжих хугацаа

2020 оны 4-р сарын 14-ээс
7-р сарын 1 хүртэл

Бид хаана ажилладаг



Өрхийн газар тариаланг дэмжих төсөл

Санхүүжүүлэгч

АДРА Канад болон Канадын үр тарианы банк

Төслийн үр шим хүртэгчсэд

Зорилтот сумдын 845 өрх болон өрхийн гишүүд



Зорилтот газар

Баян-Өлгий аймгийн Өлгий, Бугат болон Сагсай сумд.

Төсөв

375,637.00 доллар

Хэрэгжих хугацаа

2020 – 2023

Байгууллагын танилцуулга

АДРА нь бие даасан хүмүүнлэгийн байгууллага бөгөөд 1956 онд дэлхийн Долоо дахь өдрийн Адвентист сүмийн санаачлагаар хүн ардад хөгжлийн болон гамшгийн үеийн туслалцаа үзүүлэх зорилгоор анх байгуулагдсан.

АДРА нь хөгжиж буй орнуудын нийгмийн шударга бус ба тэгш бус байдлыг халах түүнчлэн туслалцаа дэмжлэг шаардлагатай нэгний амьдралын чанарыг сайжруулахыг төлөө ажилладаг. АДРА дэлхийн 120 гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд энэ орнуудын тоонд Монгол улс багтана.

АДРА нь 1994 оноос Монголд үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд 5 хөтөлбөрийн хүрээнд хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулахын төлөө олон төсөл хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хүнсний аюулгүй байдал
- Эдийн засгийг дэмжих
- Эрүүл мэнд
- Гамшгийн менежмент
- Боловсрол

Уриа

Шударга. Энэрэнгүй. Хайр

Эрхэл зорилго

АДРА Монгол нь бүтээлч хамтын ажиллагаа, хариуцлагатай үйл ажиллагаагаараа дамжуулан хэрэгцээ шаардлагатай болон эмзэг бүлгийн хүмүүсийн амьдралд бодит, эерэг өөрчлөлтийг авчирна.

Алсын хараа

АДРА Монгол нь шударга ил тод байдлыг эрхэмлэсэн мэргэжлийн, чадварлаг, шинийг эрэлхийлэгч, бүтээлч, эрч хүчтэй байгууллага байна.

АДРА Монгол нь нийгмийн болон хүмүүсийн амьдралд хэмжигдэхүйц, баримтжуулагдсан, найдвартай өөрчлөлт авчрахын тулд учирч болох саад бэрхшээл, эрсдэлийг үл тоон ажиллана.

Мөн чанар

Адвентист Хөгжил Туслалцааны Агентлаг нь Бурханы хайр, энэрлийг түгээдэг Долоо дахь Өдрийн Адвентист сүмийн үүсгэн байгуулсан, даян дэлхийд хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Таршил

Суурин төлөөлөгчийн захидал	3
АДРА-ийн тухай	5
Төсөл хэрэгжиж буй газрууд	6
Хүнсний аюулгүй байдал	8
Органик хөдөө аж ахуйн түншлэл төсөл	
Амжилтын түүх	
Хүнсний аюулгүй байдал	10
Өрхийн газар тариаланг дэмжих төсөл	
Амжилтын түүх	
Гамшгийн менежмент хөтөлбөр	12
Ковид-19 Цар тахлын яаралтай тусламж төсөл	
Амжилтын түүх	
Санхүүгийн тайлан	14
Хамтрагч Байгууллагууд	15
	16



Суурин төлөөлөгчийн ЗАХИДАЛ



2020 оны эхээр БНХАУ-ын Ухань хотод Ковид-19-ийн цар тахал дэгдэж улмаар сая сая хүн халдвар авч, нас баралтын тоо буурахгүй байгаатай холбогдуулан дэлхийн эдийн засаг зогсонги байдалд орж, олон нийтийг цочирдуулсан их хохиролтой жил байлаа.

Ковид-19 халдварын тохиолдолдлыг хумих зорилгоор дэлхий даяар болон Монгол улсад авч хэрэгжүүлсэн үечилсэн хөл хорионы үед манай хамт олон өөрсдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, төслүүдээ амжилттай хэрэгжүүлэхийн тулд зогсолтгүй ажилласаар байна.

АДРА Монгол нь энэ сорилтот үед ч байгууллагынхаа “хүн төрөлхтний сайн сайхны төлөө үйлчилснээр тэднийг Бурханы хүслийн дагуу амьдрахад нь тусална” хэмээх зорилгоо эрхэмлэхийн зэрэгцээ үндэс угсаа, хүйс, улс төрийн үзэл баримтлал болон шашин шүтлэгээс үл хамааран хүн бүрийн үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрч тэгш үйлчилсээр байна.

Түүнчлэн бид донор байгууллагуудтайгаа хамтран Баян-Өлгий аймгийн хоол тэжээлийн эх үүсвэр, амьжиргааны нэг хэлбэр болох газар тариаланг дэмжих зорилготой мэргэшсэн тариаланч бэлтгэх сургалтыг зохион байгуулсан ба Сэлэнгэ аймагт хэрэгжиж буй органик тогтвортой газар тариаланг дэмжих төсөл нь гучин хоршоотой хамтран нийт 11,303 үр шим хүртэгчдэд хүрч ажиллалаа.

Үүнээс гадна, АДРА Монгол байгууллагаас Ковид-19-ийн яаралтай тусламжийн арга хэмжээ авч Улаанбаатар хотын Баянгол, Чингэлтэй дүүрэгт 1,674 эмзэг бүлгийн иргэдэд бэлэн мөнгөний тусламж үзүүлсэн.

Тулгарч буй саад бэрхшээлүүдийн өмнө бид “шинэ хэвийн нөхцөл байдал”-д дасан зохицож, ирээдүйн зорилгоо үл умартан, үр шим хүртэгчдээ хамгийн боломжит замаар дэмжин хөгжил, хүмүүнлэгийн ажлаа урам зоригтойгоор урагшлуулсаар байна. Түүнчлэн бид Бурханы даалгасан ажлыг тууштай хийж, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийн хүмүүсийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарал хандуулан ажиллаж байна.

Манай хамт олны 2020 онд Бурханы удирдлагаар хийж бүтээсэн ажлуудаа энэхүү тайлангаараа та бүхэнд танилцуулж байгаадаа баяртай байна.

Хүндэтгэсэн,

WINDELL M. MARANAN

Суурин төлөөлөгч

АДРА Монгол



Бидний зорилго

Энэрэнгүй сэтгэлээр хандаж, Бурханы хүслээр амьдрах



2020

Тилийн тайлан